



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн лаборатори 8 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2022 /59/ НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Орхон аймаг

2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ц.Нармандах

Утас:70359826

Цахим хаяг:orkhon@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ

Утас:70355805

Цахим хаяг:erdeneb@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Оргилмөрөн

Утас:70350757

Цахим хаяг:orgilmurung@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. Аудитын тайлан	12
3.1 Ерөнхий зүйл	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	15
3.8 Аудитын гол асуудал	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт.....	17
4.1 Залруулсан алдаа	17
4.2 Төлбөрийн акт.....	17
4.3 Албан шаардлага	17
4.4 Зөвлөмж	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС
АДБОУС

Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.02.28 № 56
танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМГИЙН ЛАБОРАТОРИ
8 ДУГААР СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Д БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн 8 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн 8 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.



Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>180,776,150.40</u>	<u>172,262,537.03</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	45,000.00	0.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	45,000.00	0.00
3121	Төгрөг	45,000.00	0.00
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	45,000.00	0.00
33	АВЛАГА	0.00	7,151,810.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	0.00	7,151,810.00
35	БАРАА МАТЕРИАЛ	180,731,150.40	165,110,727.03
351	Түүхий эд материал	109,445,143.01	104,730,473.01
35110	Тусгай зориулалттай материал	109,445,143.01	104,521,473.01
35130	Эм боох материал	0.00	209,000.00
354	Хангамжийн материал	71,286,007.39	60,380,254.02
35410	Бичиг хэргийн материал	2,336,860.00	1,452,140.00
35420	Аж ахуйн материал	2,031,350.00	4,290,000.00
35470	Бусад хангамжийн материал	66,917,797.39	54,638,114.02
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,134,137,465.21</u>	<u>3,073,094,549.44</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,134,137,465.21	3,073,094,549.44
392	Биет хөрөнгө	2,426,958,298.61	2,366,077,882.88
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,533,695,506.39	2,533,695,506.39
39202	Хуримтлагдсан элэгдэл	-147,618,722.68	-224,113,366.96
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	219,416,128.65	214,029,380.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-212,455,652.08	-182,402,539.78
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	122,852,449.81	118,245,427.80
39208	Хуримтлагдсан элэгдэл	-88,931,411.48	-93,376,524.57
393	Биет бус хөрөнгө	707,179,166.60	707,016,666.56
39301	Програм хангамж	10,995,000.00	10,995,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-10,615,833.40	-10,778,333.44
39303	Бусад биет бус хөрөнгө	706,800,000.00	706,800,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>3,314,913,615.61</u>	<u>3,245,357,086.47</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>4,515,000.00</u>	<u>0.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,515,000.00	0.00
413	Өглөг	4,515,000.00	0.00
4136	Бусад өглөг	4,515,000.00	0.00
41361	Байгууллагад төлөх өглөг	4,515,000.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>3,310,398,615.61</u>	<u>3,245,357,086.47</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	3,310,398,615.61	3,245,357,086.47
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,913,974,457.75	1,913,974,457.75
51101	Өмч: - төрийн	1,207,174,457.75	1,207,174,457.75
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	706,800,000.00	706,800,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	-270,923,449.04	-335,964,978.18
51210	Өмнөх үеийн үр дүн	-180,282,432.6	-266,408,449.04
51220	Тайлант үеийн үр дүн	-90,641,016.5	-69,556,529.14
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,667,347,606.90	1,667,347,606.90
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>3,314,913,615.61</u>	<u>3,245,357,086.47</u>



2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,559,452,399.29	1,649,802,660.26
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	33,006,399.29	7,881,456.62
120	Нийтлэг татварын бус орлого	33,006,399.29	7,881,456.62
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	33,006,399.29	150,200.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,440,000.00	0.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	551,500.00	150,200.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	22,014,899.29	0.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		3,298,555.10
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		4,432,701.52
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,526,446,000.00	1,641,921,203.64
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,440,982,600.00	1,516,473,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,440,982,600.00	1,516,473,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	108,000.00	36,370,703.64
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	108,000.00	34,251,703.64
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	2,119,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	85,355,400.00	89,076,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	85,355,400.00	89,076,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,650,093,415.74	1,719,359,189.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,650,093,415.74	1,719,359,189.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,591,147,701.74	1,641,644,510.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,218,172,562.00	1,272,081,900.00
210101	Үндсэн цалин	1,058,215,726.00	981,007,890.00
210102	Нэмэгдэл	67,347,094.00	243,714,686.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,737,200.00	1,868,930.00
210104	Урамшуулал	90,872,542.00	45,490,394.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	153,216,498.00	167,508,670.00
210201	Тэтгэврийн даатгал	104,292,511.99	116,787,070.00
210202	Тэтгэмжийн даатгал	12,269,707.29	12,680,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,775,446.69	10,144,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,443,540.11	2,536,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	24,435,291.92	25,360,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	64,518,338.00	64,360,980.00
210301	Гэрэл, цахилгаан	6,627,033.00	9,158,845.00
210302	Түлш, халаалт	48,171,863.00	48,754,145.00
210303	Цэвэр, бохир ус	9,719,442.00	6,447,990.00
2104	Хангамж, бараа материалын зардал	43,426,660.67	31,622,184.89
210401	Бичиг хэрэг	260,025.00	485,350.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,642,934.00	1,178,740.00
210404	Ном, хэвлэл	2,025,260.00	217,030.00



210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	9,343,442.00	1,749,750.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,564,015.00	6,065,660.00
210408	Бараа материал акталсны зардал	19,590,984.67	21,925,654.89
2105	Нормативт зардал	664,400.00	2,314,800.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	397,400.00	774,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	267,000.00	1,540,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,376,700.00	2,045,800.00
210604	Урсгал засвар	6,376,700.00	2,045,800.00
2107	Томилолт, зочны зардал	938,600.00	304,000.00
210702	Дотоод албан томилолт	938,600.00	304,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,427,925.00	3,200,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	405,325.00	3,200,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,022,600.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	102,406,018.07	98,206,175.51
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	506,000.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,773,690.00	9,464,704.64
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	92,126,328.07	88,741,470.87
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	58,945,714.00	77,714,679.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	31,332,400.00	58,838,300.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	29,147,400.00	56,808,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,185,000.00	2,030,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	19,010,362.00	17,597,820.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,010,362.00	17,597,820.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,602,952.00	1,278,559.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,602,952.00	1,278,559.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>-90,641,016.45</u>	<u>-69,556,529.14</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-90,641,016.45</u>	<u>-69,556,529.14</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,913,974,457.75	1,667,347,606.90	-180,282,432.59	3,401,039,632.06
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,913,974,457.75	1,667,347,606.90	-180,282,432.59	3,401,039,632.06
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-90,641,016.45	-90,641,016.45
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,913,974,457.75	1,667,347,606.90	-270,923,449.04	3,310,398,615.61
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,913,974,457.75	1,667,347,606.90	-270,923,449.04	3,310,398,615.61
D02	Нягтлан бодох бүртгэлийн	0.00	0.00	4,515,000.00	4,515,000.00



	бодлогын өөрчлөлт				
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,913,974,457.75	1,667,347,606.90	-266,408,449.04	3,314,913,615.61
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-69,556,529.14	-69,556,529.14
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,913,974,457.75	1,667,347,606.90	-335,964,978.18	3,245,357,086.47

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,561,049,629.00	1,648,861,409.64
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,991,500.00	150,200.00
120	Нийтлэг татварын бус орлого	10,991,500.00	150,200.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,991,500.00	150,200.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,440,000.00	0.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	551,500.00	150,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,550,058,129.00	1,648,711,209.64
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,440,982,600.00	1,516,473,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,440,982,600.00	1,516,473,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	108,000.00	36,370,703.64
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	108,000.00	34,251,703.64
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	2,119,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	85,355,400.00	89,076,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	85,355,400.00	89,076,600.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	23,612,129.00	6,790,006.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	23,612,129.00	6,790,006.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,561,454,954.00	1,624,506,409.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,561,454,954.00	1,624,506,409.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,478,491,786.00	1,532,849,914.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,218,859,092.00	1,272,081,900.00
210101	Үндсэн цалин	818,377,527.00	815,155,302.00
210102	Нэмэгдэл	322,850,065.00	402,969,655.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,560,000.00	1,736,930.00
210104	Урамшуулал	71,071,500.00	52,220,013.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	152,428,860.00	167,508,670.00
210201	Тэтгэврийн даатгал	107,101,896.00	116,787,070.00
210202	Тэтгэмжийн даатгал	11,331,840.00	12,680,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,065,232.00	10,144,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,266,508.00	2,536,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	22,663,384.00	25,360,800.00



2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	64,518,338.00	64,360,980.00
210301	Гэрэл, цахилгаан	10,592,146.00	10,917,056.00
210302	Түлш, халаалт	45,909,664.00	43,802,797.00
210303	Цэвэр, бохир ус	8,016,528.00	9,641,127.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,493,506.00	8,026,711.00
210401	Бичиг хэрэг	780,335.00	947,291.00
210402	Тээвэр, шатахуун	80,700.00	0.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,562,234.00	1,300,270.00
210404	Ном, хэвлэл	3,018,960.00	681,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	11,344,592.00	942,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,706,685.00	4,155,850.00
2105	Нормативт зардал	1,824,310.00	2,429,800.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	492,400.00	889,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,331,910.00	1,540,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,826,700.00	7,117,800.00
210604	Урсгал засвар	1,826,700.00	7,117,800.00
2107	Томилолт, зочны зардал	727,600.00	304,000.00
210702	Дотоод албан томилолт	727,600.00	304,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,022,600.00	3,200,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	3,200,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,022,600.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,790,780.00	7,820,053.64
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	506,000.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,284,780.00	7,820,053.64
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	82,963,168.00	91,656,495.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	55,349,854.00	65,628,306.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	23,612,129.00	6,790,006.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	29,147,400.00	56,808,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,590,325.00	2,030,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	7,151,810.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		7,151,810.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	19,010,362.00	17,597,820.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,010,362.00	17,597,820.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,602,952.00	1,278,559.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,602,952.00	1,278,559.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>-405,325.00</u>	<u>24,355,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	0.00	24,400,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	24,400,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	24,400,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		24,400,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>0.00</u>	<u>-24,400,000.00</u>



8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-405,325.00	-45,000.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	450,325.00	45,000.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	45,000.00	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Дүн	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,607,393,700.0	1,586,824,321.0	20,569,379.0	98.7%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,607,393,700.0	1,586,824,321.0	20,569,379.0	98.7%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,548,665,200.0	1,528,131,021.0	20,534,179.0	98.7%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,272,081,900.0	1,272,081,900.0	0.0	100.0%
210101	Үндсэн цалин	721,293,500.0	815,155,302.0	-93,861,802.0	113.0%
210102	Нэмэгдэл	464,438,400.0	402,969,655.0	61,468,745.0	86.8%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,552,400.0	1,736,930.0	1,815,470.0	48.9%
210104	Урамшуулал	82,797,600.0	52,220,013.0	30,577,587.0	63.1%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	167,713,200.0	167,508,670.0	204,530.0	99.9%
210201	Тэтгэврийн даатгал	116,991,600.0	116,787,070.0	204,530.0	99.8%
210202	Тэтгэмжийн даатгал	12,680,400.0	12,680,400.0	0.0	100.0%
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,144,300.0	10,144,300.0	0.0	100.0%
210204	Ажилгүйдлийн даатгал	2,536,100.0	2,536,100.0	0.0	100.0%
210205	Эрүүл мэндийн даатгал	25,360,800.0	25,360,800.0	0.0	100.0%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	81,958,800.0	64,360,980.0	17,597,820.0	78.5%
210301	Гэрэл, цахилгаан	13,132,700.0	10,917,056.0	2,215,644.0	83.1%
210302	Түлш, халаалт	54,510,100.0	43,802,797.0	10,707,303.0	80.4%
210303	Цэвэр, бохир ус	14,316,000.0	9,641,127.0	4,674,873.0	67.3%
2104	Хангамж, бараа материалын зардал	7,309,600.0	7,309,521.0	79.0	100.0%
210401	Бичиг хэрэг	877,300.0	877,291.0	9.0	100.0%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,320,900.0	1,300,270.0	20,630.0	98.4%
210404	Ном, хэвлэл	701,800.0	681,300.0	20,500.0	97.1%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	350,900.0	392,000.0	-41,100.0	111.7%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,058,700.0	4,058,660.0	40.0	100.0%
2105	Нормативт зардал	2,429,800.0	2,429,800.0	0.0	100.0%
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	889,300.0	889,300.0	0.0	100.0%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,540,500.0	1,540,500.0	0.0	100.0%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,117,800.0	7,117,800.0	0.0	100.0%
210604	Урсгал засвар	7,117,800.0	7,117,800.0	0.0	100.0%
2107	Томилолт, зочны зардал	877,300.0	304,000.0	573,300.0	34.7%
210702	Дотоод албан томилолт	877,300.0	304,000.0	573,300.0	34.7%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,614,800.0	0.0	1,614,800.0	0.0%



210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,614,800.0	0.0	1,614,800.0	0.0%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,562,000.0	7,018,350.0	543,650.0	92.8%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	543,600.0	0.0	543,600.0	0.0%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,018,400.0	7,018,350.0	50.0	100.0%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	58,728,500.0	58,693,300.0	35,200.0	99.9%
2132	Бусад урсгал шилжүүлэг	58,728,500.0	58,693,300.0	35,200.0	99.9%
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	56,808,300.0	56,808,300.0	0.0	100.0%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,920,200.0	1,885,000.0	35,200.0	98.2%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,607,393,700.0	1,586,824,321.0	20,569,379.0	98.7%
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,516,473,900.0	1,498,876,080.0	17,597,820.0	98.8%
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,516,473,900.0	1,498,876,080.0	17,597,820.0	98.8%
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	89,076,600.0	87,798,041.0	1,278,559.0	98.6%
132001	Орон нутгийн төсвөөс	89,076,600.0	87,798,041.0	1,278,559.0	98.6%
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,843,200.0	150,200.0	1,693,000.0	8.1%
1E+06	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,843,200.0	150,200.0	1,693,000.0	8.1%
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	82.0	82.0	0.0	100.0%
620001	Удирдах ажилтан	1.0	1.0	0.0	100.0%
620002	Гүйцэтгэх ажилтан	65.0	65.0	0.0	100.0%
620003	Үйлчлэх ажилтан	16.0	16.0	0.0	100.0%
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	1,389.0	1,389.0	0.0	100.0%
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	1,389.0	1,389.0	0.0	100.0%
630001	Төрийн өмчит ЕБС	1,389.0	1,389.0	0.0	100.0%
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	82.0	82.0	0.0	100.0%
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	64.0	64.0	0.0	100.0%
650005	ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ)	1.0	1.0	0.0	100.0%
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	1.0	1.0	0.0	100.0%
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	16.0	16.0	0.0	100.0%

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	108,000.00	36,370,703.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	108,000.00	36,370,703.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	29,118,893.64
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	717,190.00
210401	Бичиг хэрэг		70,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.00	550,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.00	97,190.00



2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	24,400,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	24,400,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	3,200,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		3,200,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	801,703.64
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	801,703.64
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	108,000.00	7,251,810.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	108,000.00	100,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	108,000.00	100,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	7,151,810.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		7,151,810.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	108,000.00	36,370,703.64
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	108,000.00	36,370,703.64
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	108,000.00	34,251,703.64
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		2,119,000.00



3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Орхон аймгийн лаборатори 8 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд бүртгэл санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Оргилмөрөн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхон аймгийн лаборатори 8 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Орхон аймгийн 8-р сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Зорилго: Багш, сурагчдын хөгжлийг дэмжин, суралцагч бүрийн сурлагын чанар, хөгжил төлөвшлийн хүрсэн түвшинг ахиулан суралцах арга барилыг эзэмшүүл, эцэг, эх асран хамгаалагчийн хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын хууль тогтоомж, Нийгмийн даатгалын хууль тогтоомж, ТБОНӨХБАҮХАТ хууль зэрэгт өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөг сайжруулах шаардлагатай байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.



3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхон аймгийн лаборатори 8 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийн нийт зардал ба цэвэр зээлийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл **дунд** гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсвийн 1,607,393.7 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 16,073.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 11,251.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Орхон аймгийн лаборатори 8 дугаар сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 69,556.5 мянган төгрөгөөр буюу 2.1 хувиар буурсан байна. Нийт хөрөнгийн бууралт нь тайлант оны бараа материал, үндсэн хөрөнгийн бууралттай холбоотой байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	45.0	0.0	-45.0
Авлага	0.0	7,151.8	7,151.8
Урьдчилгаа			
Бараа материал	180,731.2	165,110.7	-15,620.4
Үндсэн хөрөнгө	3,134,137.5	3,073,094.5	-61,042.9
Нийт хөрөнгө	3,314,913.6	3,245,357.1	-69,556.5
Өр төлбөр	4,515.0	0.0	-4,515.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,310,398.6	3,245,357.1	-65,041.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,314,913.6	3,245,357.1	-69,556.5

Мөнгөн хөрөнгийн данс үлдэгдэлгүй болж 45.0 мянган төгрөгөөр буурсан нь ахмадын сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс тайлант онд зарцуулснаас шалтгаалжээ.

Оны эцэст нэмэлт данснаас татуулсан 7,151.8 мянган төгрөгөөр татаас санхүүжилтийн авлага үүсгэсэн байна. Энэ нь тус сургууль дээр 2021-2022 оны хичээлийн



жилд хэрэгжиж буй Шидэт цүнх төслийн үлдэгдэл 5,102.8 мянган төгрөг, түрээсийн орлогын үлдэгдэл 2,049.0 мянган төгрөгөөс бүрдэж байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 165,110.7 мянган төгрөг болж 15,620.4 мянган төгрөгөөр буурсан Захирлын 2021 оны А/45 дугаар тушаалаар 17,002.0 мянган төгрөгийн сургуульд ашиглагдахаа больсон 253 нэрийн 9397 ширхэг ном, А/46 дугаар тушаалаар эдэлгээний хугацаа дуусаад цаашид ашиглах боломжгүй болсон 4,923.7 мянган төгрөгийн тусгай зориулалтын материал тус тус акталсантай холбоотой байна. Тайлант онд 4,337.3 мянган төгрөгийн ном сурах бичиг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,073,094.5 мянган төгрөг болж 61,042.9 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант оны 24,400.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж шинээр худалдан авсан, 3,298.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж үнэ төлбөргүй хүлээн авсан хэдий ч элэгдлийн зардал 88,741.5 мянган төгрөг тул үндсэн хөрөнгийн данс буурсан байна. Мөн аймгийн Засаг даргын 2021 оны А/165 дугаар захирамжаар ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 38,215.6 мянган төгрөгийн дансны үнэтэй машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил акталсан байна.

Өр төлбөр дансны олон жил болсон үлдэгдэл 4,515.0 мянган төгрөгийг тооцоо нийлсэн акт үйлдэж өмнөх үеийн үд дүнд хаасан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,245,357.1 мянган төгрөг болж 65,041.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Орхон аймгийн лаборатори 8 дугаар сургуулийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 90,350.3 мянган төгрөгөөр буюу 5.8 хувиар өссөн байна. Өмнөх оноос орлого өссөн нь тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт болон нэмэлт санхүүжилтийн орлогоос шалтгаалсан байна.

Нийт зардал өмнөх оноос 69,265.8 мянган төгрөгөөр буюу 4.2 хувиар өссөн байна. Энэ цалин, НДШ-ийн зардал болон төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшууллын зардлын өсөлт байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн 2,003,497.0 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээр болон орон нутгийн төсвөөс, 14,443.2 мянган төгрөгийг өөрийн орлогоор бүрдүүлж, нийт зарлагыг 2,017,940.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 410854665 мянган төгрөгөөр бууруулж, тус байгууллагын 2021 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн 1,516,473.9 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 89,076.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 1,843.2 мянган төгрөгийг өөрийн орлогоос бүрдүүлж, нийт зарлагыг 1,607,393.7 мянган төгрөгөөр тооцон баталж төсөвлөсөн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71802 /Ерөнхий боловсрол/ хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр тусгай зориулалтын шилжүүлгээр 1,516,473.9 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 89,076.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, өөрийн орлогоор 1,843.2 мянган төгрөг, нийт 1,607,393.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал Аудитын код: ОРА-2022 /59/ НА-СТА-ТШЗ



үйл ажиллагаанд 1,586,824.8 мянган төгрөгийг зарцуулж 20,569.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,586,824.8 мянган төгрөг буюу 98.7 хувьтай байгаа нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 17,597.8 мянган төгрөгөөр, томилолт, зочны зардлыг 573.3 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 1,614.8 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 543.6 мянган төгрөгөөр тус тус дутуу /хэмнэсэн/ зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансны 36,370.7 мянган төгрөгийн гүйлгээ тайлагнасан байна. Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө ангиллаар 34,251.7 мянган төгрөг, Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого ангиллаар 2,119.0 мянган төгрөг авч зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн данснаас төвлөрүүлсэн 7,151.8 мянган төгрөгийг авлагаар бүртгэж тайлагнасан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудит хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Орхон аймгийн лаборатори 8 дугаар сургуулийн төвийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 талбарын мэдээллээс хугацаандаа оруулсан 142 талбарын мэдээлэл, хугацаа хоцроосон 9 талбарын мэдээлэл байна. Цалингийн



зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш орлогын 87,047.3 төгрөгийн 3 гүйлгээ, зардлын 47,805.3 төгрөгийн 4 гүйлгээ, 5 сая төгрөгөөс дээш худалдан авалтын 19,000.0 төгрөгийн 1 гүйлгээг тус тус дутуу мэдээлсэн байсныг нөхөж мэдээлэв.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 48.2 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт бүрэн төлөгдсөн, 17,799.0 мянган төгрөгийн зөрчилд өгсөн 2 албан шаардлага, мөн аудитаар хүргүүлсэн 2 зөвлөмжийн биелэлт хангагдсан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Орхон аймгийн лаборатори 8 дугаар сургуулийн санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгөн шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй ба дараагийн аудитаар бараа материал, үндсэн хөрөнгийн дансыг авч үзэж болох юм.



4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 48,376.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 42,540.5 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,434.7 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 501.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 3,900.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Нэмэлт дансны 2,049.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоор, үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийн 3,298.5 мянган төгрөгийн, бараа материалын 4,432.7 мянган төгрөгийн орлогын ангиллыг тус тус алдаатай илэрхийлсэн байна.
- Санхүүгийн үр дүнгийн тайланд цалин хөлсний 1,163.5 мянган төгрөгийг ндш-ийн зардлаар, мөнгөн гүйлгээний тайланд биет ба биет бус хөрөнгө худалдан авсан 24,400.0 мянган төгрөгийг багаж, техник, хэрэгслийн зардлаар, нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлгийн 7,151.8 мянган төгрөгийг зардлын ангиллыг алдаатай илэрхийлсэн байна.
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд ахмадын сангаас зарцуулсан 45.0 мянган төгрөгийг оруулж тайлагнасан байна.

4.2 Төлбөрийн акт

1. Нэмэлт санхүүжилтийн дансаар 2021 оны 11-р сард Цонолха жалба ХХК-аас худалдан авсан Canon MF244DW маркийн олон үйлдэлт принтерийн үнийг нэхэмжлэхийн дүнгээс 115,200 төгрөгөөр илүү дүнгээр шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 41.2.3-д “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна” гэсэн заалттай тус тус нийцэхгүй, хэмжилт болон үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:Төлбөрийн акт тогтоов

2. Тайланд оны сургуулийн цайны газрын түрээсийн орлогын 60 хувь болох 1,319,520 төгрөгийг Эрдэнэт сангийн дансанд төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41.2.1-д “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх”, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 07 дугаар тогтоолын 3-д “Орон нутгийн өмчийн байрны дам түрээсийн орлогын 60 хувийг “Эрдэнэт сан”-ийн дансанд сар бүр төвлөрүүлэхийг түрээслүүлэгч, орон нутгийн өмчит байгууллагуудын удирдлагад даалгасгай” гэж заасантай тус тус нийцэхгүй, иж бүрэн байх, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:Төлбөрийн акт тогтоов

4.3 Албан шаардлага

1. Зардлын бүлгийн эдийн засгийн ангилал, төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 43 дугаар тогтоолыг зөрчин хичээл практикийн



зардлаас 501.0 мянган төгрөгөөр оны эцэст номын дэлгүүрээс календарь, бөмбөрцөг, тэмдэглэлийн дэвтэр, атлас зэргийг худалдан авч шаардахаар зарлагдсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.3 дахь заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн шинж чанартай 3,900.0 мянган төгрөгийн үнэтэй дулааны тоолуурыг бараа материалын дансанд бүртгэсэн байна. Мөн тайлант онд худалдан авсан камер, свич, рүүтэр, хөшиг зэрэг тусгай зориулалтын эд зүйлсийг авсан тухай бүр зарлагадаж зардал болгож бүртгэж байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө", 4.1.3-д "Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт", УСНББОУС 17-д үндсэн хөрөнгө гэдэг нь "Нэгээс дээш тайлангийн хугацааны туршид ашиглагдахаар хүлээгдэж байгаа хөрөнгө юм" гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Бараа материалын дансанд бүртгэсэн үндсэн хөрөнгийн чанартай зүйлсийг үндсэн хөрөнгийн холбогдох дансанд шилжүүлэн бүртгэх.

2. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 талбарын мэдээллээс хугацаандаа оруулсан 142 талбарын мэдээлэл, хугацаа хоцроосон 9 талбарын мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш орлогын 87,047.3 төгрөгийн 3 гүйлгээ, зардлын 47,805.3 төгрөгийн 4 гүйлгээ, 5 сая төгрөгөөс дээш худалдан авалтын 19,000.0 төгрөгийн 1 гүйлгээг тус тус дутуу мэдээлсэн байсныг нөхөж мэдээлэв.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална", 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалт, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-тай тус тус нийцэхгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж, цахим хуудаст мэдээлэх мэдээллийг хугацаанд нь бүрэн гүйцэт мэдээлж, дотоод хяналтыг сайжруулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 05 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Орхон аймгийн 8-р сургууль	1	115.2			1	115.2				
2	Орхон аймгийн 8-р сургууль	1	501.0					1	501.0		
3	Орхон аймгийн 8-р сургууль	1	3,900.0							1	3,900.0
4	Орхон аймгийн 8-р сургууль	1	0.0							1	0.0
5	Орхон аймгийн 8-р сургууль	1	1,319.5			1	1,319.5				
6	Орхон аймгийн 8-р сургууль	1	9,780.2	1	9,780.2						
7	Орхон аймгийн 8-р сургууль	1	32,715.3	1	32,715.3						
8	Орхон аймгийн 8-р сургууль	1	45.0	1	45.0						
Дүн		8	48,376.2	3	42,540.5	2	1,434.7	1	501.0	2	3,900.0